

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Энэхүү өсөлт нь АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрийн ахицтай байдалтай холбоотой юм. S&P 500 индексийн сагсанд багтах экспортод мэдрэг технологийн салбар, үйлдвэрлэлийн салбар болон түүхий эдийн салбар өсөлттэй хаагдлаа. Харин бондын өгөөж өссөнөөс үүдэн ус, дулаан, цахилгаан хангамжийн салбарын компаниудын өндөр ногдол ашиг хөрөнгө оруулагчдын анхаарлыг татахаа больж эхэлснээс үүдэн эдгээр компаниудын хувьцааны үнэ буурлаа. Хээрийн галыг бууруулах зорилгоор Калифорни мужийн цахилгааныг тасалснаас үүдэн Pacific Gas & Electronics (PG&E) компанийн хувьцааны ханш огцом буурлаа.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп өөрийн twitter хуудсанд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны гэрээний эхний шат хэрэгжиж эхэлсэн хэмээн мэдэгдсэнтэй холбоотой хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлт үзүүлсэн ба Мичиганы Их Сургуулийн тооцдог хөрөнгө оруулагчдын хандлагын индекс өсөлт үзүүлээ.

Хувьцааны зах зээлийн эерэг мэдээ нь бондын зах зээлд сөргөөр нөлөөллөө. АНУ-ын Засгийн газрын 10 жилийн хугацаатай үнэт цаасны үнэ 23 функтээр өсжээ. Шинжээчдийн үзэж байгаагаар бондын зах зээл нь хувьцааны зах зээлийн хариу үйлдлийг дагасан буюу АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрийн ахицтай байдал нь хөрөнгө оруулагчдыг дахин илүү эрсдэлтэй үнэт цаасыг сонирхох үндэс болжээ.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрийн ахиц болон хэлэлцээртэй Brexit-ийн ахицтай байдалтай холбоотой өсөлттэй хаагдлаа.

Их Британи улсын ерөнхий сайд ноён Борис Жонсон болон Ирландын ерөнхий сайд Лео Варадкар нар 3 цагийн турш хэлэлцэний дүнд хэлэлцээр хийх боломжийн аль аль тал хэрж байгаа талаар мэдээлсэн ба Европын холбооны эрх баригчид ирэх хоногуудад хэлэлцээр хийхэд нээлттэй байгаа гэхдээ хэлэлцээрт Ирландын арлыг тусгаарласан хил байх ёсгүй гэдгийг анхаарах хэрэгтэй хэмээн мэдэгджээ. Шинжээчдийн үзэж байгаагаар Их Британи улс Европын холбооноос хэлэлцээргүй гарах магадлал 50% гэж үзэж байна.

8-р сард ХБНГУ-ын экспортын хэмжээ 1.8%-аар буурсан нь шинжээчдийн таамаглаж байснаас их байлаа. Европын холбооны хамгийн том эдийн засаг болон ХБНГУ-ын эдийн засгийн өсөлт нь дэлхийн эдийн засгийн удаашрал болон улс орнуудын худалдааны маргаанаас үүдэн удаашралтай байна. ХБНГУ-ын эрх баригчид 2020 оны эдийн засгийн өсөлтийг 1.5%-аас 1.1% болгон бууруулсан ба энэ оны хүлээгдэж буй эдийн засгийн өсөлт 0.5% буюу хямралд маш ойрхон байгаа юм.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Гэхдээ, Япон улсын Засгийн газраас бизнес эрхлэх орчин муудаж байна гэсэн мэдэгдэл хийжээ. Энэхүү мэдэгдэл нь 8-р сарын бизнесийн орчны индекс нь 99.3 болон буурсантай холбоотой байлаа. Япон улсын Засгийн газрын энэхүү мэдэгдэл нь Япон улсын эдийн засаг хямрахад ойрхон байгааг илэрхийлж байгаа юм.

БНХАУ: БНХАУ болон АНУ-ын хоорондын Вашингтон хотноо Баасан гарагт зохион байгуулагдах дээд хэмжээний уулзалттай холбоотойгоор БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп БНХАУ-ын эрх баригчидтай хийсэн уулзалт нь үр дүнтэй байсан хэмээн мэдэгджээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,001.36	-0.94% ▼
Dow Jones	АНУ	26,816.59	0.91% ▲
S&P 500	АНУ	2,970.27	0.62% ▲
Nasdaq	АНУ	8,057.04	0.93% ▲
S&P/TSX	Канад	16,415.16	-0.21% ▼
FTSE 100	Их Британи	7,247.08	1.28% ▲
S&P/ASX 200	Австрали	6,606.80	1.38% ▲
Nikkei 225	Япон	21,798.87	1.82% ▲
Hang Seng	Хонг Конг	26,308.44	1.89% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.27
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.56
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.50
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.06
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.98
DBM' 2023	USD	7.250%	104.62
TDBM' 2020	USD	9.375%	102.54
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.26

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.914	-0.06 ▼
Libor 3M	2.000	-0.03 ▼
Libor 6M	1.976	0.02 ▲
Libor 1YR	1.956	0.10 ▲
US 2YR Bond	1.591	0.21 ▲
US 3YR Bond	1.565	0.23 ▲
US 5YR Bond	1.554	0.23 ▲
US 10YR Bond	1.729	0.22 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.10.11	Өөрчлөлт
USD	2,670.53	0.11% ▲
CNY	377.86	1.25% ▲
EUR	2,942.39	0.77% ▲
RUB	41.47	1.25% ▲
KRW	2.25	1.81% ▲
JPY	24.68	-0.80% ▼
CAD	2,021.14	0.95% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,489.01	-1.04% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	17.54	-0.04% ▼
Зэс	USD/lb.	262.80	2.56% ▲
Нүүрс	USD/MT	68.43	1.65% ▲
WTI газрын тос	USD/bbl.	54.70	3.57% ▲
Brent газрын тос	USD/bbl.	60.51	3.67% ▲

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VIII	8.90%
Бодлогын хүү	2019. VIII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VIII	11.26%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	11.42%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VIII	4.99%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	16.94%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VIII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 42 компанийн 221.2 сая төгрөгийн 744,047 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Авто импекс” /AOI/ компанийн хувьцаа 11.30%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,920.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Стандарт проперти групп” /BBD/ компанийн хувьцаа 26.23%-аар буурч 107.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 1 ширхэг үнэт цаас 0.1 сая төгрөгөөр арилжаалагджээ.


10-р сарын 11-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,493.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,001.36 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.94%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	221.2
Зах зээлийн үнэлгээ	2,493,074.3

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,001.36	-0.94% ▼
MSE I индекс	9,040.52	0.15% ▲
MSE II индекс	7,436.99	-1.26% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Инвескор ББСБ	38,719	74,463,292
Говь	173,271	47,907,824
Таван толгой	3,390	22,034,365
АПУ	27,279	13,950,125
Монос хүнс	206,910	12,129,487

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Авто импекс	1,920.00	11.30% ▲
Монос хүнс	64.40	7.35% ▲
Айтүүлс	83.00	6.41% ▲
Багануур	1,001.00	4.82% ▲
Би Ди Сек	880.00	3.04% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Стандарт проперти групп	106.97	-26.23% ▼
Фронттиер лэнд групп	175.00	-12.50% ▼
Мон-ит булигаар	7,200.00	-10.00% ▼
Монголын цахилгаан холбоо	405.00	-10.00% ▼
Ариг гал	3,300.00	-8.33% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Инвескор Капитал	89,809,871
Ард Секюритиз	50,254,940
Ти Ди Би Капитал	47,986,010
Би Ди Сек	41,332,882
Бумбат-Алтай	34,547,458

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	526.36	560,143
Таван толгой	6,490.00	341,797
МИК Холдинг	14,390.00	298,007
Говь	278.13	216,973
Инвескор ББСБ	2,017.00	144,675

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	1	101,000	101,000	101,000	156	15.140%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.09.09-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Эрдэнэс тавантолгой: “Хуримтлалтай-хувьцаатай иргэн” аян хэрэгжүүлнэ

Монголын Улсын хүн амын 2/3 нь хувьцааг нь эзэмшиж байгаа “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн зүгээс хувьцаа эзэмшигчид болон иргэддээ хөрөнгийн зах зээлийн анхан шатны мэдлэг олгох аяныг хэрэгжүүлэхээр болжээ.

Энэхүү “Хуримтлалтай-Хувьцаатай иргэн” аяны хүрээнд 21 аймаг 330 суманд амьдарч буй иргэдэд хувьцаа, хөрөнгийн зах зээлийн талаарх анхан шатны мэдлэг өгөх сургалт явуулж, үнэт цаасны данс нээх үйл ажиллагааг зохион байгуулах юм байна.

Аян 2019.10.14-ны өдрөөс 2019.11.13-н хүртэл үргэлжлэх ажээ.

Эх сурвалж: MarketInfo.mn



Бирж дээр байгаа хамгийн хямд үнэтэй 10 хувьцаа

Өнөөдөр Монголын хөрөнгийн бирж дээр 198 хувьцаат компани байгаа бөгөөд тэдгээрийн хувьцааны ханш зах зээл дээр харилцан адилгүй үнийн дүнтэй байна.

Энэ удаа тус бирж дээр байгаа хамгийн хямд үнэтэй 10 компанийг танилцуулж байна. Та бүхэнд эдгээр хувьцаанаас 1 ширхгийг авснаар уг компанийн хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагч болдог бөгөөд хуулиар олгогдсон ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох зэрэг үндсэн эрхүүдийг эдэлдэг юм.

ХАМГИЙН БАГА ҮНЭТЭЙ 10 ХУВЬЦАА				
Баялаг сүмбэр BAJ 3.0₮ Сүүлд арилжигдсан огноо /2000.09.29/	Говийн өндөр JGL 10.0₮ Сүүлд арилжигдсан огноо /2006.04.25/	Талын гал TAL 15.87₮ Сүүлд арилжигдсан огноо /2018.05.02/	Увс хүнс HUN 20.0₮ Сүүлд арилжигдсан огноо /2005.04.13/	Тулгар TLP 20.0₮ Сүүлд арилжигдсан огноо /2006.12.18/
Мерекс MRX 20.0₮ Сүүлд арилжигдсан огноо /2019.09.30/	Их нуур IHN 20.0₮ Сүүлд арилжигдсан огноо /2013.10.15/	Ремикон RMC 24.11₮ Сүүлд арилжигдсан огноо /2019.10.09/	Өлзий дундговь ULZ 30.0₮ Сүүлд арилжигдсан огноо /2007.11.22/	Лэндн ББСБ LEND 48.99₮ Сүүлд арилжигдсан огноо /2019.10.11/

Эх сурвалж: MarketInfo.mn

Үнэт цаасны зах зээлийн суурь мэдлэг олгох сургалт 10-р сарын 21-нд эхэлнэ

Үнэт цаасны зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржээс сар бүр зохион байгуулдаг Үнэт цаасны зах зээлийн суурь мэдлэг олгох сургалт 10 дугаар сарын 21-ний өдрийн 14:00 цагт эхэлнэ. Сургалт хөрөнгийн биржийн сургалтын танхимд Даваа-Баасан гаригийн 14:00-18:50 цагийн хооронд явагдах бөгөөд үнэт цаасны зах зээлд ажиллаж байгаа мэргэжлийн байгууллагын удирдлагууд, мэргэжилтнүүд онол, практик хосолсон хэлбэрээр хичээлийг удирдан явуулна.

Бүртгэл: Сургалтын бүртгэл онлайнаар болон МХБ-ийн байранд явагдана.

Холбоо барих утас: 11-313747 /3312/, 11-313747 /3316/

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Атар өргөө: “Таван богд трейд” ХХК, “Улаанбаатар гурил” ХХК-ийн хувьцаа саналын эрхгүй болов

2017 оны 12-р сард Атар өргөө /MSE:ATR/-ийн 69,425 ширхэг буюу 39.9%-ийг худалдан авсан “Таван богд трейд” ХХК болон “Улаанбаатар гурил” ХХК-ийн хувьцааг саналын эрхгүй болохыг шүүхээс тогтоон шийдвэрлэжээ.

Тодруулбал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн хуралдаанаас уг тогтоолыг гаргасан талаар СЗХ-ноос мэдэгдэв. Өөрөөр хэлбэл Бэрэн групп-ын гаргасан нэхэмжлэлийг шүүхээс хангасан гэсэн үг юм.

Тус компани нь сүүлийн 2 жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүй, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөж байгаа талаар бид өмнө мэдээлж байсан билээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

Баялаг сүмбэр: Шинэ худалдан авагч ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг өөрчилнө

Баялаг сүмбэр /MSE:BAJ/-ийн 89.6%-ийг Ванвату улсын иргэн Yeh Montgomer худалдан авсан талаар бид өмнө мэдээлж байсан билээ.

Тэгвэл тус компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа ирэх сарын 18-нд хуралдуулахаар товлосон байна. Энэ удаагийн хурлаар компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэнэ. Өөрөөр хэлбэл компанийн шинэ хөрөнгө оруулагч удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээ бүрдүүлж байгаа аж.

Эх сурвалж: MarketInfo.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХАА-н нэмүү өртгийн төслүүдтэй танилцав

Манай улсад хэрэгжүүлж буй агробизнесийн хувийн хэвшлийн ААН-үүдэд хөрөнгө оруулах “ХАА, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төслийн явц болон үр дүнтэй ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан танилцлаа.

Дээрх төсөл нь ААН-үүдэд хөрөнгө оруулах замаар хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох, Монгол Улсын эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор хэрэгжиж байна.

Төслийн үр дүнд ашиглалтгүй байгаа мал аж ахуй болон ХАА-н бусад баялаг, нөөцийн нэмүү өртгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ХАА-н бүтээгдэхүүнд суурилсан ААН, хоршоодод нэмүү өртгийн сүлжээ (НӨС)-г хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийх юм. Мөн түүхий эд үйлдвэрлэгч, анхан шатны тордолт, хамгаалалт хийдэг малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдүүлэхэд чиглэж байна. Ингэснээр ХАА-н бүтээгдэхүүнд суурилсан ААН-үүдийн маркетинг, чадвар, чадавхи дээшилж Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт тодорхой түвшинд шат ахина гэж төсөл хэрэгжүүлэгчид үзэж байгаа юм.

Төслийн хүрээнд АХБ-ны 50 сая ам.долларын санхүүжилт бүхий 25 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээлийг өгч хэрэгжүүлнэ. АХБ болон Төслийн удирдах хороо нийт 86.9 тэрбум төгрөгийн өртөгтэй 37 зээлийг батлаж, 78.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу хийгээд байна. Эдгээр төслүүд амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр цаг хугацаандаа хийгдэж байгааг болон төслийн зохицуулагч Ж.Түвшинсанаа ХХААХҮ-ийн сайд Ч.Улаанд танилцуулав.

Тухайлбал, “ГБТ трейдинг” ХХК хүлэмжийн аж ахуй эрхлэн, даршилсан нарийн ногоо тариалж, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Зүүнхараа сумын жижиг тариалагчдын тариалалтыг дэмжсэн нарийн ногооны бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэн өргөтгөж байна. Ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Баялаг өлзий” ХХК-ийн хувьд зээлийн зарцуулалтаа сүлжих цехэд Японы “Шимасейки” машинууд авч суурилуулан бүтээмжийн гарцаа өсгөн, сарлагийн хөөвөр болон торомны ноосон бүтээгдэхүүний нэмүү өртгийг нэмэгдүүлж, маркетингийн үйл ажиллагааг идэвхижүүлэхэд зарцуулжээ.

Мөн борлонгийн ноолуур, торомны бүтээгдэхүүнийнхээ хувьд Монголын “Хаан ширхэгт” стандартыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор малчидтай нягт хамтран ажиллаж байна. Зээлээ үр дүнтэй зарцуулснаар экспортоо 16, борлуулалт 9.5 хувиар нэмэгдүүлж чаджээ. Тус компани дотоодоосоо гадна Унгар улсад өөрийн дэлгүүр нээжээ. Тонг төхөөрөмж нэмж суурилуулснаар үйлдвэрлэл нэмэгдэж, 44 ажлын байр шинээр бий болжээ.

Эх сурвалж: Montsame.mn

Ноолуур дунджаар 53-64 мянган төгрөгийн үнэтэй байна

Ямааны цагаан ноолуурын үнэ Орхон, Хөвсгөл аймагт кг нь 65 мянган төгрөг байна.

Энэ нь хамгийн өндөр үнэ бөгөөд бусад аймагт дунджаар 53-64 мянган төгрөгийн үнэтэй байна. Баянхонгор, Булган, Дорнод аймагт ноолуур кг нь 50 мянган төгрөг байгаа нь хамгийн бага үнэ болж байна.

ҮСХ-ноос гаргасан малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр нас гүйцсэн эр хонь Орхон аймагт 200 мянган төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ болж байна. Харин Дорнод аймагт эр хонь 125 мянган төгрөгийн үнэтэй байна.

Хонины ноостой нэхийний дундаж үнэ Орхон аймагт 3.5 мянган төгрөг, Завхан, Увс аймагт 1.5 мянган төгрөг, бусад аймагт 2.5-3.0 мянган төгрөг байна.

Эх сурвалж: Montsame.mn



Чулуун нүүрс, алтны экспорт нэмэгджээ

Монгол Улс энэ оны эхний есөн сарын байдлаар, дэлхийн 145 улстай худалдаа хийж гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.5 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар өссөн байна. Үүнээс экспорт 5.9 тэрбум ам.доллар, импорт 4.6 тэрбум ам.долларт хүрч нэмэгджээ.

Экспорт өмнөх оны мөн үеэс 663 сая ам.доллараар нэмэгдэхэд чулуун нүүрсний экспорт 312 сая ам.доллар, алтны экспорт 199 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Харин импорт өмнөх оны мөн үеэс 247 сая ам.доллараар нэмэгдэхэд эрдэс бүтээгдэхүүний импорт 40 сая ам.доллар, дизель түлш 93 сая ам.доллар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 179 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт экспортын 95 гаруй хувийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт эзэлж байгаа юм. Харин импортын 68 орчим хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.